



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# #3

2022 он

V сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

## Монгол улсын боловсролыг хувирган өөрчлөх нь (transforming education) сэдэвт үндэсний хэлэлцүүлэг

### БЭЛТГЭЛ АЖИЛ

2022.V.01 - V.25

I үе шат	Удирдамж боловсруулах	Бэлтгэл үйл ажиллагааг хангах, төсөв гаргах	Менежмент багт хүлээлгэн өгөх	Виртуал орчинд байршуулах	Сурталчилгаа хийх
-------------	-----------------------	---	-------------------------------	---------------------------	-------------------

### ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

2022.V.25 - VI.15

II үе шат	Орон нутгийн хэлэлцүүлгийн бэлтгэл, удирдамж гаргах	Цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	Орон нутгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах	Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэсэн тайлан нэгтгэл
--------------	---	---	---	---

### ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

2022.VI.28 - VI.29

III үе шат	Үндэсний хэлэлцүүлгийн бэлтгэл хангах	Танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	Үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулах	Хэлэлцүүлгийн нэгдсэн дүгнэлт	Орон нутаг болон үндэсний хэлэлцүүлгийн нэгдсэн тайлан бэлтгэх
---------------	---------------------------------------	--	---	-------------------------------	--

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын зарласан, 2022 оны IX сард болох "Боловсролыг хувирган өөрчлөх нь" сэдэвт дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улс оролцохоор бэлтгэж байна. Бэлтгэл ажлын хүрээнд үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулах бөгөөд уг ажлыг үндэсний хэлэлцүүлгийн зохицуулагч БШУ-ны сайдын удирдлага доор БСҮХ удирдан зохион байгуулна.

Хэлэлцүүлгийн гол зорилго нь боловсролын салбарт КОВИД 19-өөс үүдсэн сөрөг нөлөөг даван туулах, ТХЗ-4-ийн хэрэгжилтийг хангах, ирээдүйн боловсролын бодлого, төлөвлөлт, санхүү-

жилтийн талаар хэлэлцэж, Монгол Улсын 2030 он хүртэлх боловсролын хэтийн зорилтыг тодорхойлоход чиглэх юм.

Хэлэлцүүлэгт боловсролын байгууллагаас гадна хүүхэд залуучууд, нийгмийн хамгаалал, ААН бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж, тодорхой сэдэвчилсэн агуулгаар хэлэлцүүлэг өрнүүлэх болно.

БСҮХ Үндэсний хэлэлцүүлгийг тодорхой үе шаттайгаар, танхимын болон танхимын бус хэлбэрийг хослуулан зохион байгуулахаар ажиллаж байна.

### Цар тахлын үеийн боловсрол, ирээдүйд авах арга хэмжээ

Цар тахлын үед улс орнууд суралцагчдад тасралтгүй, хүртээмжтэй боловсролыг хэрхэн олгож ямар арга хэмжээ авч байсан талаарх мэдээллийг орчуулан хүргэж байна. [Мэдээллийн дэлгэрэнгүй:](#)



### Залуу судлаачдыг чадавхжуулах цуврал семинар



БСҮХ-ийн залуу судлаачдад зориулан эрдэм шинжилгээний өгүүлэл бичих аргазүйн талаарх семинарыг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр "Өгүүллийн оршил ба сэдвийн судлагдсан байдал" сэдвээр доктор З.Тогтохмаа зохион байгууллаа. Тус семинараар судалгааны өгүүллийн оршил, сэдвийн судлагдсан байдал,

ялгаа, тэдгээрийг бичих аргачлал, үе шатын талаар мэдээлэл хуваалцаж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Түүнчлэн БСҮХ-ээс эрхлэн гаргадаг "Эрдэм шинжилгээний бичиг"-ийг "Боловсролын судалгааны монгол сэтгүүл" нэрээр цахим хэлбэрээр гаргах ажлын үйл явцын талаар танилцуулсан юм.

### "Тэгш хамруулах боловсрол" зөвлөгөөн



"Бүх нийтийн боловсролын төлөө" Иргэний нийгмийн үндэсний эвслээс зохион байгуулсан "Тэгш хамруулах боловсрол" зөвлөгөөнд оролцлоо. Уг зөвлөгөөний зочноор Португалын иргэн, доктор, DED (Disability, Education and Development) байгууллагын захирал, олон улсын тэгш хамруулах

боловсролын зөвлөх Паула Фредерико Хант уригдан оролцож, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц: Тэгш хамруулан сургах боловсрол эзэмших эрхийн талаарх 2016 оны 4 дүгээр ерөнхий зөвлөмж "Суралцахуйн түгээмэл загвар" танилцуулга хийв.

### "Дижитал чадамжийн хэрэглэгдэхүүн ба боловсролын нээлттэй нөөц материал" хэлэлцүүлэг



ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газартай хамтран "Дижитал чадамжийн хэрэглэгдэхүүн ба боловсролын нээлттэй нөөц материал" онлайн хэлэлцүүлэг 2022 оны 05 сарын 20-нд зохион байгуулагдлаа. Хэлэлцүүлэгт дижитал чадамжийг хөгжүүлэх, боловсролын нээлттэй нөөц материалын (БННМ) цахим санг үүсгэх аргачлал, хөтөлбөрүүдийг танилцуулж, оролцогч талууд санал солилцлоо.

### “Боловсролын салбар дахь жендэрийн шинжилгээ” судалгааны товч тайлангаас...

 БШУЯ-ны СХОГ-ын Санхүүгийн хэлтэс, БСҮХ-ийн Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны секторын хамтын ажиллагааны дагуу уг судалгааг 2022 оны 5 дугаар сарын 23-30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн судалгааны тайланг хүргүүлэв.

Боловсролын салбарын жендэртэй холбоотой бодлогын болон эрх зүйн

судалгаа шинжилгээний бүтээлийн нэгтгэлийг гаргаж, улмаар холбогдох салбарт ажиллагчид, суралцагчдын хүйсийн харьцааг тодруулах зорилгоор уг судалгааг хийв.

Жендэрийн тэгш бус байдлын индекс (ЖТББИ) нь хүйсийн тэгш бус байдлаас шалтгаалах нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсролын байдал болон шийдвэр

гаргах эрх мэдэл, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоогоор хэмжигдэх нийлмэл индекс юм.

Манай улсын жендэрийн тэгш бус байдлын индекс 2021 онд 0.367 болж, 2011 онтой (0.390) харьцуулахад 0.023 пунктээр буурсан бол өмнөх оноос 0.081 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн нийт эмэгтэйчүүдийн 94.6 хувь, нийт эрэгтэйчүүдийн 95.3 хувь нь дундаас дээш боловсролтой байна.

Хүснэгт 1. Дундаас дээш боловсролтой хүн амын эзлэх хувь (хүйсээр)

Бүс	Дундаас дээш боловсролтой хүн амын эзлэх хувь	
	Эмэгтэй	Эрэгтэй
Баруун бүс	65.4	63.8
Хангайн бүс	75.9	73.5
Төвийн бүс	84.6	80.8
Зүүн бүс	78.8	75.7
Улаанбаатар	94.6	95.3

Дундаас дээш боловсролтой хүн амын судалгааг бүсчилсэн байдлаар харвал Улаанбаатарт хамгийн өндөр, харин баруун бүсэд хамгийн бага хувьтай байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15 ба түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.7 хувь байгаа нь 2010 оныхоос 0.4 пунктээр өссөн байна. Үүнээс эрэгтэйчүүдийнх 0.4 пунктээр, эмэгтэйчүүдийнх 0.6 пунктээр нэмжээ.

Эх сурвалж: 1212.mn

### Онцлох зарим ажлууд

**1** "Дээд боловсролын чанарын баталгаажуулалт: Сургалтын технологи, хэрэгжилт, үр дүн" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд секторын эрхлэгч, доктор С.Батцэцэг нар "Эдийн засгийн боловсролын эрэлт, хэрэгцээ ба багш бэлтгэх тогтолцоо" сэдвээр, "Цахим, виртуал эдийн засаг ба нийгэм: Сорилт ба боломжууд" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд секторын ЭШАА, доктор, дэд профессор Б.Баярцэцэг нар "Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрийн хүртээмж" сэдвээр илтгэл тавьж тус тус хэлэлцүүлэв.

**2** Боловсролын салбарын бүх шатны сургалтын байгууллагын сэтгэл ханамжийн судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулахаар судалгааны бэлтгэл шатанд дараах ажлуудыг хийж байна. Үүнд: судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах, цахимаар мэдээлэл цуглуулах ажлын зураглал гаргах зэрэг болно.

**3** НҮБ болон Монгол Улсын Засгийн газар одоогоос эхлээд 2030 он хүртэлх хугацаанд боловсролыг хувирган өөрчлөх шинэ буюу шинэчилсэн үндэсний түвшний алс хэтийн зорилтыг тодорхойлоход тус болох үзүүлэх зорилгоор оролцоог хангасан үндэсний хэмжээний хэлэлцүүлэг зохион байгуулахыг зорин ажиллаж байна. Энэхүү үндэсний хэлэлцүүлгийн "Боловсролын санхүүжилт" агуулгын бэлтгэлийг хангах ажлыг тус сектор ахлан ажиллаж байна.

**Кембрижийн их сургуулийн мэргэжилтнүүд орон нутагт...**

Кембрижийн их сургуультай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, замын зураглалын төсөл боловсруулж батлуулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлын судалгаа хийх зорилгоор тус секторын эрхлэгч Х.Отгонбаатар, эрдэм шинжилгээний ажилтан Б.Эрдэнэчимэг, Ж.Дэнсмаа нар Дорнод, Орхон аймгуудад ажиллалав.

БШУЯ, БСҮХ, БЕГ, БҮТ, Кембрижийн их сургуулийн хамтарсан баг нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдалтай танилцах ажлын хүрээнд Дорнод, Орхон аймгийн БШУГ-ын дарга, мэргэжилтэн, Дорнод аймгийн V сургууль, Орхон аймгийн лаборатори VIII сургууль, Жаргалант сумын дунд сургуулийн удирдлага, багш, сурагч, эцэг эхийн төлөөлөл, Дорнод их сургуулийн удирдлага, багш, оюутнуудтай уулзалт зохион байгуулж, зарим хичээлд ажиглалт хийж, тухайн орон нутаг дахь сургалт, үйл ажиллагаа болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдалтай танилцлаа.

**Газарзүйн боловсролын салбарынхан тулгамдсан асуудал, хэлэлцүүлэг**

БЕГ, БСҮХ МУБИС, МУИС, Ховд Их сургуультай хамтран “Газарзүйн боловсролд тулгамдсан асуудал, шийдэл-2022” Үндэсний хэлэлцүүлгийг 2022 оны 5 дугаар сарын 13-нд зохион байгуулав.



Тус хэлэлцүүлэгт танхимаар их дээд сургуулийн багш нар, оюутнууд, ахмад багш нарын төлөөлөл, БШУЯ, БЕГ, БСҮХ, Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн төлөөлөл, онлайнгаар аймаг, нийслэлийн ЕБС-ийн газарзүйн багш нар 71 цэгээс тус тус оролцлоо.

**Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр**

Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төслийг боловсруулах, сайжруулах ажлыг гүйцэтгэж, хөтөлбөрийн төслийн баримт бичиг, хөтөлбөрийн танилцуулгыг албан бичгийн хамт БШУЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын хэлтэст хүлээлгэн өглөө.

**Дээд боловсролын хөтөлбөрийн хүртээмжийн шинжилгээ**

Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрийн шинэчлэл нь оюутанд дараах 3 түвшинд сонголт хийх боломжийг олгосон байна.

1. Ерөнхий суурь хичээлийн чиглэлүүдэд заасан багц цагийн агуулгын хүрээнд сонгох,
2. Оюутан тухайн хөтөлбөрийн дагуу багц цагийн хичээл амжилттай судалсан тохиолдолд мэргэших чиглэлээ сонгох,
3. Оюутан тухайн сургуулийн бакалаврын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжоор хэрхэн хангагдсан талаар судаллаа.

**“Сурах эрх” сэдэвт хэлэлцүүлэг**

“Сурах эрх” сэдэвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар БШУЯ, БСҮХ, БЕГ хамтран хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш, оюутнууд, ЕБС-ийн удирдлага, багш нар, эцэг эхийн төлөөлөл, аймаг, нийслэлийн БШУГ -ын мэргэжилтний төлөөллөөс бүрдсэн 200 орчим хүн оролцлоо.

### Тархи судлалын судалгааны хүрээлэнгийн удирдлага, эрдэм шинжилгээний ажилтнуудтай хийсэн ажил хэргийн уулзалт

БСҮХ-ийн удирдлага, ББСС-ийн төлөөлөл ШУА-н харьяа ТССХ (Тархи судлалын судалгааны хүрээлэн)-ийн удирдлага, эрдэм шинжилгээний ажилтнуудтай ажил хэргийн уулзалт зохион байгууллаа.

Уулзалтаар тархи сэтгэл судлалын судалгааны үр дүнг боловсрол, сургалтын үйл ажиллагаанд тусгах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцлоо.

### БСҮХ-ийн ЭША-уудад зориулсан Microsoft-ын программын сургалт



БСҮХ нь 2 долоо хоног тутамд онол, арга зүйн семинарыг нийт ажилтнуудынхаа дунд зохион байгуулаад удаагүй байгаа билээ.

2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн семинараар онол, арга зүйн сургалтаас гадна ЭША-ы ур чадварыг дээшлүүлэх

зорилгоор Microsoft-ийн зарим программын сургалтыг зохион байгууллаа.

Энэхүү сургалтыг цаашид үе шаттайгаар зохион байгуулж, ЭША-ы ур чадварыг дэмжин ажиллах юм.

### Захиргааны зөвлөлийн хурал

БСҮХ-ийн Захиргааны зөвлөлийн хурал 2022 оны 05 дугаар сард нийт 4 удаа хуралдаж, 10 асуудлаар хэлэлцэж, 6 шийдвэр гаргасан байна.

### "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ"

Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 372 дугаар тогтоолоор "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ"-г баталсан юм.



Тус тогтоолын 4.2.5, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2022 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 4.2.3.1.1-д заасны дагуу БСҮХ-ийн Гадаад хэлний төв, БЕГ, Улаанбаатар хот дахь "Бритиш скул" ХХК-тай хамтран энэ оны 05 дугаар сарын 16-аас 06 дугаар сарын 11-ний өдрийн хооронд 1 сарын хугацаанд ЕБС-ийн 10 багшийг англи хэлний заах арга зүйг хөгжүүлэх, сургагч багш бэлтгэх, 100 хувь гадаад багштай сургалтад хамруулаад байна.

## Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийн талаарх судалгааны үр дүн



БСҮХ, ХХСС нь БШУЯ, ШУТС- тай хамтран “Монгол хүүхдийн цогц хөгжлийн онцлог” 2 шатны судалгааг гүйцэтгэсэн бөгөөд 2 дахь шатны судалгааны мэдээллийг Улаанбаатар хот, Хөвсгөл, Дорнод, Орхон, Дорноговь, Завхан аймгийн 3-17 насны 4950 хүүхдээс мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулав.

Судалгааны үр дүнг олон нийтэд дэлгэрүүлэх үүднээс 2 эрдэм шинжилгээний хуралд 4 илтгэл хэлэлцүүлсэн нь энэ сарын онцлох ажил байна.

“6-17 насны хүүхдийн бие бялдрын хөгжлийн онцлог”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэхүй хөгжлийн онцлог” сэдвээр “Отгон тэнгэр” Их сургуулиас зохион байгуулсан ЭШХ-д илтгэлээ хэлэлцүүлэв. Илтгэлээр Монгол хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, цаашид хөгжлийг дэмжих арга замын талаар, 11-17 настай хүүхдийн сэтгэн бодох үйл ажиллагааны ерөнхий онцлог, сэтгэхүйн хөгжлийг дэмжих арга зүйн талаарх мэдээллийг тусгасан.

Дараагийн эрдэм шинжилгээний хурлын хэлэлцүүлгийг Олимпийн академиас зохион байгуулсан бөгөөд тус ЭШХ-д

Монгол хүүхдийн бие бялдрын хөгжилд гарч байгаа өөрчлөлт, мөн хүүхдийн цогц хөгжилд хичээлээс гадуурх үйл ажиллагааны нөлөөллийн талаарх судалгааны үр дүнг танилцуулсан нь практик ач холбогдолтой боллоо. Судалгааны үр дүнд 6-17 настай хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил, бэлтгэлжилт нь өмнөх 1 дүгээр шатны судалгаанаас ямар ялгаатай, мөн хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо, ялангуяа спортын уралдаан тэмцээнд оролцдог хүүхдүүдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудын онцлогийн талаарх мэдээллийг хурлаар хэлэлцүүлээ.

## Үндэсний статистикийн хорооны зохион байгуулсан “Төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн судалгаа”-нд үндэслэсэн сургалт



Монгол улсын ҮСХ-оос “Төрийн байгууллагуудын өгөгдлийн сангийн судалгаа”-ны хүрээнд явуулсан сургалтад оролцон, судалгаанд хамрагдав. БСҮХ -ийн Хүний хөгжлийн судалгааны секторын “Монгол хүүхдийн хөгжлийн судалгаа” -ны өгөгдлийн сангийн дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулсан байна. Тус сургалт төрийн байгууллагуудын мэдээллийн санг цаашид боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлох, статистикийн мэдээллийн сантай холбох нөхцөлийг судлах, түүнтэй уялдуулах, сангуудыг хооронд нь холбох ажлыг эхлүүлэх зорилготой юм.

## БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих программ хангамжуудын хөгжүүлэлт



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “Open journal systems” үнэгүй программ хангамжийг ашиглан хөгжүүлж байна. “Open journal systems” нь цахим академик сэтгүүлд зориулан хөгжүүлсэн систем юм.



Мөн судалгаа авах <http://survey.mnier.mn/> программыг нэвтрүүлэхэд бэлэн болж байна.

## Баян-Өлгий аймгийн II-V ангийн сурагчдад зориулсан монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилт судалгаа

Баян-Өлгий аймгийн II-V ангийн монгол хэлний хичээлийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийн туршилтыг Өлгий сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль, Сагсай, Толбо сумын сургуульд бага ангийн багш нарын дэмжлэг, оролцоотойгоор амжилттай туршлаа.



турш туршилтын хичээл заалаа. Тус сургуулийн сургалтын менежерүүд, зохиогчийн баг, бага ангийн багш нар хичээлд суун, анализ хийж, хичээл заасан багш бүрийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, дараах саналуудыг гаргасан юм.

Тэднээс ирсэн саналыг тоймлон үзүүлбэл:

1. Сонсох даалгавар маш сайн байгааг дурдаад багш, сурагчид өөрсдөө шууд хэрэглэх оновчтой хувилбараар, сайн уншдаг хүүхдээр уншуулахад анхаарах.
2. Гарын авлага, дасгал ажлын дэвтрийг хэрэглэх үед заавар, таних тэмдэг нь ойлгомжтой байхыг чухалчлах.
3. Даалгаврын тавил сайн байна. Зарим сэдвийн даалгаврыг багасгах.
4. Зураг, дизайн нь (тодруулах, томруулах) анхаарах.

Зохиогчийн баг өөрсдөө хичээлд хамт суун, гарын авлага, дасгал ажлын дэвтрийг сайжруулах, зарим даалгаврыг засах талаар тухай бүрд тэмдэглэж авлаа.

Сурагчид хичээлийн агуулгыг ихэд сонирхон идэвхтэй гүйцэтгэж байгаагаас иймэрхүү гарын авлага, дасгал ажлын дэвтрийг хэрэглэж хэвшвээс сурагчдын монгол хэлний хичээлийн чанар сайжирч, идэвх оролцоо нь нэмэгдэж, бодит өөрчлөлт гарах нь туршилт-судалгаагаар харагдлаа.

Туршилтыг зохион байгуулсан: БСҮХ-ийн МХБСАТ-ийн ЭША Ж.Гэрэлмаа.

### Туршилтын судалгааны товч тайлангаас...

Туршилтад анги тус бүрээс 2 анги, нийт 10 бүлэг хамрагдлаа. Гарын авлага, дасгал ажлын дэвтрийн 10 дугаар бүлэг сэдвийг туршиж, багш бүрээр тэмдэглэл хөтлүүлэн, цаашид анхаарах, сайжруулах асуудлыг тодорхойлж авсан нь чухал алхам болов.

Гарын авлага, дасгал ажлын дэвтрийг хүүхдийн тоогоор хувилж, тарааж өгч ажиллуулав. Гарын авлагын багийн зохиогч нар тус сургуулийн багш, сургалтын менежертэй хамтран, хичээлийн хуваарь гаргаж, хуваарийн дагуу 2 долоо хоногийн

5. Нэмэлтээр шинэ үгийн тольтой байх хэрэгтэй байна.
6. Зарим хүнд үгсийг хялбаршуулан өгөхөд анхаарч ажиллах.
7. Алдаатай үг хэллэгийг залруулах.
8. Зарим эхийг өөр эхээр солих.
9. Дэвтэрт яг юуг ажиллуулах талаар ойлгомжтой болгох.
10. Эх дотор олон шинэ үг орохгүй байхаар даалгавруудыг тавих шаардлагатай гэжээ.

